## ДУНДГОВЬ АЙМГИЙН ТАТВАРЫН ХЭЛТСИЙН 2023 ОНЫ АВЛИГЫН ЭСРЭГ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ

| Д/Д | ЗОРИЛГО, ЗӨВЛӨМЖ | ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ | ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ | ХУГАЦАА | ХЭРЭГЖИЛТ | ХУВЬ |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| ***1. 2023-2024 оныг "Авлигатай тэмцэх жил" болгон зарласан Засгийн газрын 2023 оны 49 дүгээр тогтоолыг хэрэгжүүлэх*** | | | | | | |
| 1.1 | Авлигатай тэмцэх чиглэлээр авч хэрэгжүүлэх ажиллагаа, арга хэмжээний хэрэгжилтийг хангаж, бүх талын дэмжлэг үзүүлж ажиллах | "Авлигатай тэмцэх жил" болгон зарласан Засгийн газрын тогтоол, "5Ш" хөтөлбөр, "Авлигын эсрэг үндэсний хөтөлбөр"-ийг албан хаагчид хүргэн сурталчлах, Засгийн газар, эрх бүхий байгууллагын шийдвэрийг хэрэгжүүлж, дэмжлэг үзүүлэн ажиллах | Арга хэмжээг хэрэгжүүлж, тайлан, мэдээг хугацаанд нь хүргүүлсэн байх | Жилд | ТЕГ-т 2 удаа, АЗДТГ-т 2 удаа хүний нөөцийн судалгааг өгөгдсөн хүснэгтийн дагуу хугацаанд нь гаргаж хүргүүлсэн. | 100 |
| ***2.Авлигын эсрэг үндэсний чуулганаас гаргасан зөвлөмжийг хэрэгжүүлэх*** | | | | | | |
| 2.1 | Төрийн албаны их өгөгдөлд суурилсан хүний нөөцийн нэгдсэн удирдлагын цахим системийг хөгжүүлэх, ашиглалтыг нэмэгдүүлэх, ялангуяа их өгөгдөлд суурилсан төрийн албан хаагчийн томилгоог хийх, энэхүү системийг төрийн байгууллагуудын цахим системтэй интеграцжуулахад холбогдох байгууллагууд дэмжлэг үзүүлэн хамтран ажиллах | Төрийн албаны зөвлөлийн их өгөгдлийн санд татварын албаны хүний нөөцийн бүртгэлийг бүрэн оруулах, их өгөгдлийн санд суурилсан албан хаагчийн томилгоог хийх, төрийн байгууллагуудтай хамтран ажиллах | Системд мэдээллийг тухай бүрт шинэчлэх | Жилд | Төрийн албаны хүнийн нөөцийн hrm.csc.gov.mn системд 29 албан хаагчийн мэдээллийг тухай бүрт шинэчилэн оруулсан. | 100 |
| 2.2 | *Зөвлөмж 2.4.* Төрийн албаны хууль тогтоомжоор албан тушаалд тавигдсан шаардлагыг хангаагүй, сонгон шалгаруулалтгүйгээр томилсон хүмүүсийг төрийн албанаас чөлөөлөх, томилсон этгээдэд хариуцлага тооцох, албан тушаалтны буруутай шийдвэрийн улмаас төрд учирсан хохирлыг гэм буруутай этгээдээр нөхөн төлүүлэхэд онцгой анхаарах | Албан тушаалын шаардлагыг хангаагүй албан хаагчийг томилохгүй байх, албан үүргийг түр орлон гүйцэтгэгчээр томилсон албан тушаалд тусгай шалгалт зарлан томилох | Төрийн албаны тухай хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлсэн байх | Эхний хагас жилд, жилд | Сул орон тооны захиалыг ТАСЗ-д 3 удаа хүргүүлж, ерөнхий болон тусгай шалгалтанд тэнцсэн 2 албан хаачгийг ТАЗ-ийн дүгнэлтийг үндэслэн холбогдох материалын ТЕГ-т хүргүүлэн томилсон. Мөн түр орлон гүйцэтгэгчээр ерөнхий шалгалтанд тэнцсэн 2 албан хаагчийг томилуулан ажиллуулж байна. | 100 |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
|---|---|---|---|---|---|---|
| ***3.Авлигын эсрэг үйл ажиллагааны чиглэлээр*** | | | | | | |
| 3.1 | Авлигын эсрэг хууль тогтоомжийг иргэдэд сурталчлах, соён гэгээрүүлэх үйл ажиллагааны хүртээмжийг нэмэгдүүлэх | 1.АТГ-аас бэлтгэсэн шторк, инфографик, нийтлэл, зурагт хуудас, цахим ном, гарын авлага зэргийг олон нийтэд хүргэсэн байх | Мэдээллийг байршуулан түгээсэн байх | Жилд | Дундговь аймгийн татварын хэлтэс пэйж хуудсаар нийт 8 пост, 23 шэйр байршуулж 511 иргэнд түгээсэн байна.<br>Авлигын буланд 110 дугаарыг сурталчилсан материал, зурагт хуудсыг тавьж сурталчилсан. Авлигын эсрэг өдрийг тохиолдуулан байгууллагын албан хаагчдын дунд Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд хийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн хүрээнд асуулт хариултын тэмцээн зохион байгуулж албан хаагчдыг бүрэн хамруулсан.<br>Шударга ёс, хөгжил дэвшилд аян, Хүний эрхийн олон улсын өдөр, Авлигын эсрэг өдрийг тохиолдуулан АЗДТГ-аас зохион байгуулсан “Мэдлэг ба ур чадвар” тэмцээнд амжилттай оролцож тусгай байр эзэлсэн. | 100 |
| | | 2.Авлигын эсрэг үйл ажиллагааг мэдээлэн сурталчлах “Шударга ёс, хөгжил дэвшилд 110” мэдээллийн самбар ажиллуулах | Мэдээллийг сар бүр шинэчлэх | | | |
| 3.2 | Авлигын эсрэг сургалт зохион байгуулах, сургалтад хамруулах | 1.Шинээр томилогдсон болон эрсдэл өндөртэй ажлын байранд ажиллаж байгаа албан хаагчдыг авлига, ашиг сонирхлын зөрчлийн эсрэг, ёс зүйн сургалтад хамруулсан байх; | Сургалтад хамруулсан байх | Жилд | 1.Шинээр томилогдсон 4 татвар хураагч, 1 мэргэжилтэнд дагалдуулах сургалтыг 4 удаа зохион байгуулсан.<br>2.ХАСХОМ, ХАСУМ гаргадаг 24 албан хаагчид 2 удаа сургалт зохион байгуулсан.<br>3.ТЕГ-аас зохион байгуулсан төрийн албан хаагчийн ёс зүй | 100 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | 2.Албан хаагчдад авлигын эсрэг, төрийн албан хаагчийн ёс зүйн сургалтыг зохион байгуулах | Өөрсдийн нөөц бололцоонд тулуурлан зохион байгуулсан байх; | | цахим сургалтад нийт албан хаагчид 100 хувь хамрагдсан.<br>4.Прокурорын газраас Авилгаас ангид байж, ажил үүргээ гүйцэтгэсний төлөө төлөө шан харамж авахгүй байх зэргээр ашиг сонирхлын зөрчилд автахаас урьдчилан сэргийлэх талаар сургалтыг 16 албан хаагчдад зохион байгуулсан.<br>5.Татварын албаны үйлчилгээ, ажилтан, албан хаагчид тавих ерөнхий шаардлага стандартаар 2 удаа 19 албан хаагчид сургалт зохион байгуулсан. | |
| 3.3 | Авлигын эсрэг үйл ажиллагаандаа олон нийтийн хяналтыг бий болгох | 1.Төрийн байгууллага, хувийн хэвшлийн хооронд байгуулах аливаа гэрээ хэлэлцээрт авлигаас урьдчилан сэргийлэх асуудлыг тусгах талаар зохион байгуулалтын арга хэмжээ авсан байх; | Байгуулсан бүх гэрээнд авлигаас ангид байх асуудлыг тусгасан байх | Жилдээ | 1.Худалдан авалтыг нийт 18 байгууллагатай хамтран ажиллаж, гэрээнд заалтыг тусган хэрэгжүүлж ажилласан<br>2.Шилэн дансанд мэдээллийг тухай бүр оруулж, санхүүгийн мэдээллийн ил тодын самбартаа хэлтсийн төсөв, санхүүгийн талаарх мэдээллийг нийтэд ил байршуулсан.<br>3.Байгууллагын хэмжээнд https://du.mta.gov.mn/ вэб сайттай болсон. | 100 |
| | | 2.“Төрийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх журам”-ыг хэрэгжүүлэх | Хэрэгжүүлэн ажиллах | | | |
| 3.4 | Авлига, ашиг сонирхлын зөрчил үүсэх шалтгаан, нөхцөлийг арилгуулах арга хэмжээ авах | 1.Авлигын эрсдэл ба авлига гарах боломжийг бууруулах чиглэлээр холбогдох арга хэмжээг авч үйлчилгээг цахимжуулах | Үйлчилгээг цахимжуулсан тоног төхөөрөмж суурьлуулсан байх | Жилд | Албаны үйл ажиллагаа 100 хувь цахимжсан. Татвар төлөх КИОСК машин, посс машин АЗДТГ-ийн дэмжлэгээр авч хэлтэст байршуулан, цахимаар татвар төлөх боломжийг илүү нэмэгдүүлж татвар төлөгчид таатай нөхцөлийг бүрдүүлсэн<br>2.АЗДТГ санхүү төрийн сангийн хэлтэс, ТИНЗ, МНБИ-тэй хамтран 1 удаа, А хэлэлцүүлэг | 100 |
| | | 2.Салбарын хэмжээнд авлигаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг тодорхойлох, хүнд суртлыг бууруулах чиглэлээр хэлэлцүүлэг, уулзалт зохион байгуулах | Хэлэлцүүлэг, уулзалтын үр дүнд арга хэмжээ зохион байгуулсан байх; | | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | 3.Үйлчлүүлэгчдээс авлигын эрсдэл, үйл ажиллагааны хүндрэл бэрхшээлийг тодорхойлох сэтгэл ханамжийн судалгаа авч, судалгааны дүгнэлтэд тулгуурлаж арга хэмжээ зохион байгуулах. | Сэтгэл ханамжийн судалгааг авах Бодитой үр дүнг тооцсон байх | | зохион байгуулсан. Авлигын эсрэг олон улсын өдрийг тохиолдуулан “Мэдлэг ба ур чадвар” сургалт хэлэлцүүлгийн арга хэмжээнд оролцсон.<br>3.Татвар төлөгчдөөс цахим хуудас болон цаасаар дамжуулан 2 удаа санал асуулгыг авч нэгтгэсэн. | |
| 3.5 | Байгууллагын удирдлагын авлигатай тэмцэх хүсэл эрмэлзэл, санаачлага өрнүүлэх | 1.Удирдлагын зүгээс 2023 оны авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг 2023 оны 1-р улиралд, хэрэгжилтийн явцыг эхний хагас жилд, хэрэгжилт, хүрсэн үр дүнг жилийн эцсээр нийт албан хаагчдаа танилцуулах | Төлөвлөгөө боловсруулан батлуулсан байх Тайлан мэдээг хуулийн хугацаанд хүргүүлсэн байх | Жилд | 1.Төлөвлөгөөг боловсруулан хэлтсийн даргаар батлуулан хэрэгжилтийг ТЕГ-т 2 удаа, АЗДТГ-т 1 удаа хүргүүлсэн<br>2.АТГ-аас ирүүлсэн зөвлөмжийн 3 заалтыг төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлж буй тухай, авлигын төлөвлөгөөний хэрэгжилтийг 16 албан хаагчдад 1 удаа танилцуулан ажилласан.<br>3.Төлөвлөгөөний хэрэгжилт 100 хувийн гүйцэтгэлтэй байна. | 100 |
| | | 2."Татвар төлөгчийн өдрүүд"-ийн хүрээнд Авлигатай тэмцэх газартай хамтран олон нийтэд чиглэсэн авлигын эсрэг сурталчилгааны ажлыг зохион байгуулах | "Татвар төлөгчийн өдрүүд"-г зохион байгуулах төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлсэн байх | | Төлөвлөгөөнд тусган батлуулж, цахимаар 8 пост байршуулан 511 иргэнд танилцуулсан. | |
| **ГҮЙЦЭТГЭЛИЙН ДУНДАЖ ХУВЬ** | | | | | | **100** |

**ТАЙЛАГНАСАН:**

ХУУЛИЙН МЭРГЭЖИЛТЭН /М.УУГАНЦЭЦЭГ/

# АЖЛЫН ТАЙЛАН

АВЛИГЫН ЭСРЭГ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН

2023 оны 12 дугаар сарын 05-ны өдөр | Дугаар №01 | Мандалговь хот

Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг Засгийн газрын 49 дүгээр тогтоол, АЗДТГ, ТЕГ, АТГ-ын зөвлөмж зэргийг үндэслэн 3 зорилт, 8 арга хэмжээ бүхий төлөвлөгөөг боловсруулан хэлтсийн даргаар батлуулан хэрэгжилтийг хангаан ажиллаж байна. Төлөвлөгөөнд тусгагдсан дагуу дараах арга хэмжээг зохион байгуулан ажиллав.

1."Авлигатай тэмцэх жил" болгон зарласан Засгийн газрын тогтоол, "5Ш" хөтөлбөр, "Авлигын эсрэг үндэсний хөтөлбөр"-ийг албан хаагчид хүргэн сурталчлах, Засгийн газар, эрх бүхий байгууллагын шийдвэрийг хэрэгжүүлж, дэмжлэг үзүүлэн ажиллахах зорилтын хүрээнд ТЕГ-т 2 удаа, АЗДТГ-т 2 удаа хүний нөөцийн судалгааг өгөгдсөн хүснэгийн дагуу хугацаанд нь гаргаж хүргүүлсэн.Ө

2.Төрийн албаны зөвлөлийн их өгөгдлийн санд татварын албаны хүний нөөцийн бүртгэлийг бүрэн оруулах, их өгөгдлийн санд суурилсан албан хаагчийн томилгоог хийх, төрийн байгууллагуудтай хамтран ажиллах арга хэмжээний хүрээнд төрийн албаны хүнийн нөөцийн hrm.csc.gov.mn системд 29 албан хаагчийн мэдээллийг тухай бүрт шинэчилэн оруулсан. Сул орон тооны захиалыг ТАСЗ-д 3 удаа хүргүүлсэн. Тайлант жилд ерөнхий болон тусгай шалгалтыг өгөн тэнцсэн 2 албан хаагчийн материалыг ТЕГ-т хүргүүлэн жинхлэн томилогдсон, түр орлон гүйцэтгэгчээр 2 албан хаагч томилогдсон. Зөрчилтэй томилгоо гараагүй.









*Зураг 1. Албаны пейж хуудсаар мэдээлэл дамжуулсан байдал*




*Зураг 2. Мэдээллийн самбар байршуулсан байдал*

3. Шинээр томилогдсон Б.Оргилмаа, Б.Нандин-Эрдэнэ, Б.Бүжинлхам, Э.Намжилдулам, М.Ууганцэцэг нарт ТЕГ-аас ирүүлсэн дагалдуулах сургалтын агуулгын хүрээнд сургалтыг 4 удаа зохион байгуулсан.

4. ХАСХОМ, ХАСУМ гаргадаг 24 албан хаагчид 1 удаа сургалт зохион байгуулсан.

5.ТЕГ-аас зохион байгуулсан төрийн албан хаагчийн ёс зүй цахим сургалтад алба хаагчид 100 хувь хамрагдсан.

6. Аймгийн Прокурорын газраас “Авлигаас ангид байж, ажил үүргээ гүйцэтгэсний төлөө төлөө шан харамж авахгүй байх зэргээр ашиг сонирхлын зөрчилд автахаас урьдчилан сэргийлэх” талаар сургалтыг 16 албан хаагчдад зохион байгуулсан.

7. Татварын албаны үйлчилгээ, ажилтан, албан хаагчид тавих ерөнхий шаардлага стандартаар хэлтсийн дарга, 2 удаа 19 албан хаагчид сургалт зохион байгуулсан.






ISO 9001:2015


ДУНДГОВЬ АЙМГИЙН ТАТВАРЫН ХЭЛТЭС


Хязгаарлалтын хүрээ
Хуулийн дагуух хязгаарлалт
Хууль бус хязгаарлалт


ДУУ ХУУРЫН ӨЛГИЙ ДУНДГОВЬ НУТАГ МИНЬ











*Зураг 3.Сургалт, хэлэлцүүлэг зохион байгуулсан байдал*

8. Авлигын буланд 110 дугаарыг сурталчилсан материал, зурагт хуудсыг тавьж сурталчилсан. Авлигын эсрэг өдрийг тохиолдуулан байгууллагын албан хаагчдын дунд Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд хийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн хүрээнд асуулт хариултын тэмцээн зохион байгуулж албан хаагчдыг бүрэн хамруулсан.

9. Дундговь аймгийн төрийн байгууллага дунд зохион байгуулагдсан “Шударга ёс, хөгжил дэвшилд” аянд нэгдэж танилцуулга, самбар, материал зэргийг аялуулсан.

10.Хүний эрхийн олон улсын өдөр, Авлигын эсрэг өдрийг тохиолдуулан АЗДТГ-аас зохион байгуулсан “Мэдлэг ба ур чадвар” тэмцээнд амжилттай оролцож тусгай байр эзэлсэн.






*Зураг 4. Арга хэмжээнд оролцсон байдал*

11.Төрийн байгууллага, хувийн хэвшлийн хооронд байгуулах аливаа гэрээ хэлэлцээрт авлигаас урьдчилан сэргийлэх асуудлыг тусгах талаар зохион байгуулалтын арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллахдаа худалдан авалтыг нийт 18 байгууллагатай хамтран ажиллах гэрээнд заалтыг тусган хэрэгжүүлж ажиллалаа.

2023 ОНД ХУДАЛДАН АВАЛТ ХИЙХЭЭР ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ААН

1. Бичиг хэргийн материал-Мөнхбаялаг ресурс ХХК, Мөнхгал инвест ХХК, Ялгуумбилэгт ХХК, Тэмүжин фото студи,
2. Аж ахуйн материал, бусад - Мандалийн говийн хурд, Шувуутай-Оргил ХХК, Тогоогийнговь ХХК, Дэлгэрэхсудал ХХК
3. Барилгын материал- БуянтчандманьХХК, Ихтойн ХХК, Мөнгөлөг ХХК,
4. Халаалт, цэвэр бохир ус-Тэвшийнговь, Дундговь ус ОНӨҮГ
5. Интернет - Мобинет ХХК, Юнивишн, МЦХ ТӨХК
6. Шатах тослох материал – Магнай трейд ХХК , БМБХ ХХК
7. Гэрэл цахилгаан - БЗӨБЦТС ТӨХК

12. Байгууллагын удирдлагын авлигатай тэмцэх хүсэл эрмэлзэл, санаачлага өрнүүлэх, Авлига, ашиг сонирхлын зөрчил үүсэх шалтгаан, нөхцөлийг арилгуулах арга хэмжээний хүрээнд татвар төлөх КИОСК машин, посс машин АЗДТГ-ийн дэмжлэгээр авч хэлтэст байршуулан, цахимаар татвар төлөх боломжийг илүү нэмэгдүүлж татвар төлөгчид таатай нөхцөлийг бүрдүүлсэн

13.Татвар төлөгчдөөс цахим хуудас болон цаасаар дамжуулан 2 удаа санал асуулгыг авч нэгтгэсэн ба ямар нэгэн гомдол ирээгүй. Мөн авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан хэлтсийн даргаар батлуулж хэрэгжилтийг ТЕГ-т 2 удаа, АЗДТГ-т 1 удаа хүргүүлсэн. Тус төлөвлөгөөнд АТГ-аас ирүүлсэн зөвлөмжийн 3 заалтыг төлөвлөгөөнд тусган хэрэгжилтийг 16 албан хаагчдад 1 удаа танилцуулан ажилласан. "Татвар төлөгчийн өдрүүд"-

ийг зохион байгуулах төлөвлөгөөнд тусган батлуулж, цахимаар 8 пост, уриа, логог байршуулан 511 иргэнд танилцуулан ажиллалаа.




*Зураг 5. Арга хэмжээнд оролцсон байдал*

ХЯНАСАН: ДАРГА................................/М.ТУЯАЦЭЦЭГ/

/гарын үсэг/ /овог, нэр/

БОЛОВСРУУЛСАН:ХУУЛИЙН МЭРГЭЖИЛТЭН................../М.УУГАНЦЭЦЭГ/

/гарын үсэг/ /овог, нэр/